

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024-2028 ОНЫ
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.1. Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хүрэх түвшин, үр дүн, шалгуур үзүүлэлтийн хамт жил бүр баталж, түүний хэрэгжилтийг зохион байгуулан ажиллахыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Ж.Бат-Эрдэнэ/-д даалгасугай.

3. Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандоржид даалгасугай:

1/ Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах арга хэмжээний зардлыг жил бурийн төсөвт тусгуулах;

2/ Жил бурийн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Ж.Бат-Эрдэнэ/-д танилцуулах.

Гарын үсэг

Монгол Улсын Их Хурлын 2024 оны
... дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Улсын Их Хурлын алсын хараа

Монгол Улсын Их Хурал эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлж, Монголын ард түмний засаглах эрхийг хангана.

Монгол Улсын Их Хурлын эрхэм зорилго

Монгол Улсын Их Хурал хүн төвтэй, нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэсэн, тогтвортой хөгжил, инновацыг дэмждэг, олон ургалч үзлийг хангасан парламент байна.

Монгол Улсын Их Хурлын үнэт зүйлс

- хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах;
- олон ургалч үзлийг хангах, үр нөлөөтэй байх;
- ил тод, нээлттэй, хүртээмжтэй байх;
- ёс зүйтэй, хариуцлагатай, хариуцан тайлагнадаг байх.

Стратегийн зорилго 1. Улсын Их Хурал хүн төвтэй, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн үзэл санааг төгөлдөржүүлнэ.

1.1. Улсын Их Хурал хууль, тогтоомж болон түүнийг боловсруулах, төлөвлөх, өргөн мэдүүлэх, хэлэлцэх, батлах, биелэлтэд хяналт тавих, тайлагнах бүх үе шатад хүн төвтэй үзэл санаанд сууриссан, хүний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалсан байх агуулга, шаардлагыг нэн тэргүүнд тавина.

1.2. Улсын Их Хурал иргэдийн мэдэх эрхийг хангаж, ил тод, нээлттэй үйл ажиллагаа явуулан, иргэдийн санал бодлыг сонсох, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн талуудын тэгш оролцоог хангах нөхцөлийг сайжруулна.

1.3. Улсын Их Хурал олон талт түншлэлийг хөгжүүлж, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагууд хууль тогтоох ажиллагаанд хувь нэмэр оруулах боломж олгосон шинэ арга замыг нэвтрүүлнэ.

Хүрэх үр дүн:

- Батлагдсан хууль тогтоомжид хүний эрх баталгаатай хангагдсан байна.
- Хууль тогтоомжийг боловсруулахдаа хүн төвтэй үзэл санаанд суурисан арга барил, хууль зүйн техникиг шилжсэн байна.
- Хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад иргэний мэдэх эрх, иргэд, олон нийт, иргэний нийгмийн оролцоо хангагдсан байна.

Стратегийн зорилго 2. Улсын Их Хурал үндэсний язгуур эрх ашгийг дээдэлж, тогтвортой хөгжлийг дэмжсэн, цаг үеийн шаардлага, нийгмийн эрэлт хэрэгцээг мэдэрсэн цогц шийдвэр гаргана.

2.1.Хууль тогтоомж Монгол Улсын хөгжлийн зорилт, бодлогын уялдаа, залгамж чанарыг хангасан, судалгаа, нотолгоо, хууль хэрэглээний практикт суурисан байна.

2.2.Улсын Их Хурал хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих тасралтгүй байнгын тогтолцоог бэхжүүлж, хууль тогтоомжийн үр нөлөөг тогтмол судлан, үр дүнг үндэслэн хуулийг чанаржуулна.

2.3.Нийгэм, эдийн засгийн шинэ тутам үүсэж буй харилцаа, цаг үеийн хэрэгцээ шаардлагыг тогтмол шинжлэн судлах, түүнд үндэслэн хууль тогтоомжийн төслийн санал боловсруулах байнгын тогтолцоог бүрдүүлнэ.

Хүрэх үр дүн:

- Улсын Их Хурлаас батлан гаргах хууль тогтоомж үндэсний язгуур эрх ашигт нийцсэн, хөгжлийг дэмжсэн байна.
- Хууль тогтоомж, хөгжлийн бодлогын уялдаа холбоо хангагдаж, үр нөлөө дээшилсэн байна.
- Хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих тасралтгүй, байнгын тогтолцоо бэхжиж, эргэх хариуцлагын тогтолцоо бүхий механизм бүрдэж, хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.
- Нийгмийн харилцаанд тулгамдсан тодорхой асуудлыг цаг үеийн шаардлагад нийцүүлэн шийдвэрлэхдээ тогтмол судалгаа, дүн шинжилгээ, хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний үнэлгээнд үндэслэсэн байна.

Стратегийн зорилго 3. Улсын Их Хурал шинжлэх ухаан, инновац, технологийн дэвшилийг дэмжинэ.

3.1.Хууль тогтоомж болон түүнийг боловсруулах, төлөвлөх, өргэн мэдүүлэх, хэлэлцэх, батлах, биелэлтэд хяналт тавих, сурталчлах бүх үе шатад шинжлэх ухаанд суурисан инновац, технологийн дэвшилийг дэмжинэ.

3.2.Их өгөгдөл суурилсан мэдээлэл, дүн шинжилгээг шийдвэр гаргахад ашиглана.

3.3.Цахим парламентыг хөгжүүлэх бодлогыг тууштай баримталж, кибер аюулгүй байдлын эрх зүйн орчныг сайжруулна.

Хүрэх үр дүн:

- Улсын Их Хурлаас батлагдан гарагаа хууль, бодлого шинжлэх ухаан, инновац, технологийн дэвшилийг дэмжсэн байна.
- Шийдвэр гаргахад их өгөгдөл суурилсан мэдээлэл, дүн шинжилгээнд суурилсан байх тогтолцоо бүрдсэн байна.
- Мэдээлэл солилцох, хуулийн төсөл дээр ажиллах, судалгаа хөгжүүлэлт хийх, хяналт тавих цахим системүүдийг хөгжүүлэн нэвтрүүлж, цаг хугацаа, санхүүгийн болон бусад нөөцийн төлөвлөлт, гүйцэтгэл тодорхой болж, Улсын Их Хурлын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө хэмжигдэхүйц нэмэгдсэн байна.

Стратегийн зорилго 4.Улсын Их Хурал олон ургалч үзэл бүхий шинэ үеийн парламентыг бэхжүүлнэ.

4.1.Парламентын үйл ажиллагаанд олон ургалч үзлийг хөхиүүлэн дэмжиж, гишүүд төлөөллийн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлнэ.

4.2.Иргэд парламентын гишүүдтэй олон талт сувгаар холбогдох нөхцөлийг сайжруулж, парламентын гишүүд сонгогчдын өмнө ажлын гүйцэтгэл, ёс зүйтэй байдлаа хариуцан тайлагнадаг, хариуцлагын тоогтолцоог төлөөвшүүлнэ.

4.3.Ардчиллын үнэт зүйлсийг эрхэмлэн, хүний эрх, эрх чөлөө, жендерийн эрх, тэгш байдлыг хангах, хүний хөгжлийг дэмжихэд чиглэсэн бүх нийтэд хүртээмжтэй, соён гэгээрүүлэгч шинэ үеийн парламентыг бэхжүүлнэ.

Хүрэх үр дүн:

- Улсын Их Хурал төлөөллийн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал дээшилж, парламентад итгэх иргэдийн итгэл бэхжэсэн байна.

Стратегийн зорилго 5.Улсын Их Хурал үйл ажиллагааныхаа үр нөлөөг дээшлүүлнэ.

5.1.Улсын Их Хурлын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчлан таниулахдаа нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлсэн дэвшилтэд арга, хэрэгсэл ашиглана.

5.2. Улсын Их Хурлын гадаад харилцааг өргөжүүлж, парламент хоорондын хамтын ажиллагааг шинэ агуулга, хэлбэрээр баяжуулан хөгжүүлнэ.

5.3. Олон улсын хүний эрхийн механизм, бус нутгийн ба олон улсын байгууллагуудын үйл ажиллагаанд парламентын оролцоог нэмэгдүүлнэ.

5.4. Шинэ үеийн парламентын хэрэгцээ, шаардлагад нийцсэн ажлын албыг бэхжүүлнэ.

Хүрэх үр дүн:

- *Иргэдийн мэдэх эрх, үнэн бодит мэдээлэл авах нөхцөл сайжирсан байна.*
- *Олон улсын тавцанд Улсын Их Хурлын нэр хүнд дээшилж, байр суурь бэхжэксэн байна.*

---оОо---